



“Хорвоо ертөнцийн сайн сайхан бүтээл бүхэн инженерүүдийн уйгагүй хөдөлмөртэй салшгүй холбоотой. Инженер хүний хувьд аливаад хязгаар үгүй, гайхамшигтай ирээдүй хүлээж байдаг; улс орон бүхэнд олон янзын ажил мэргэжил шинээр үүсэж, эзэмших шаардлага тулгардаг ч бүтээлч сэтгэлгээтэй, сэргэлэн цовоо залууст тохирох үүнээс илүү сайхан мэргэжил үгүй билээ. Төсөөлөн бодох нь шинжлэх ухааны мэдлэгтэй нэгэн адил нэн шаардлагатай чадвар юм”

- Уильям Халкроу, Инженер

GERMAN - MONGOLIAN INSTITUTE
FOR RESOURCES AND TECHNOLOGY

GMIT Campus, 2nd khoroo, Nalaikh district, Ulaanbaatar
Phone: +976 7023 2086
admission@gmit.edu.mn
www.gmit.edu.mn

The development of GMIT and its cooperation with German Partner universities is supported by the Mongolian Ministry of Education and Science, and the Federal Government of Germany. The German contribution to GMIT is implemented by the Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) and the German Academic Exchange Service (DAAD).

МГТИС-ийн хөгжил болон Германы хамтрагч их дээд сургуулиудын хамтын ажиллагаа зэргийг хоёр улсын Засгийн газар дэмжин ажилладаг. Монгол Улсаас БШУЯ болон Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) болон Германы эрдмийн солилцооны алба (DAAD)-наас хариуцан, хэрэгжүүлэгч байгууллагаар ажиллаж байна.

To apply, visit our registration page for step-by-step application instructions:
<http://www.gmit.edu.mn/registration.html>
Thank you.

БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ

германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Implemented by

Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

DAAD
Deutscher Akademischer Austauschdienst
German Academic Exchange Service

Энэхүү бүтээлүүдийг байгаль, ээлтэй, цаасаар хэвлэв.
This product was printed on eco-friendly paper.



МОНГОЛЫН ШИНЭ ҮЕИЙН ИНЖЕНЕРҮҮДИЙН ДАВАЛГААНД НЭГДЭЦГЭЭ!

GERMAN - MONGOLIAN INSTITUTE
FOR RESOURCES AND TECHNOLOGY



GERMAN МЭДЛЭГ - МОНГОЛ УХААН

GERMAN МЭДЛЭГ - МОНГОЛ УХААН

“Байгалийн нөөц, технологи”-ийн шинжлэх ухааны магистрын хөтөлбөр (M.Sc.)

Монгол, Герман хоёр улсын Засгийн газрын хамтын ажиллагааны хүрээнд төрийн өмчит Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийг 2013 онд байгуулсан. Тус сургууль нь олон улсын түвшинд магадлан итгэмжлэгдсэн бакалаврын хөтөлбөрийн сургалтыг Англи хэлээр явуулдаг онцлогтой. Бид Европын сургалтын стандартын дагуу дадлагад суурилсан инженер, технологийн шилдэг боловсролыг олгож байна. Олон улсын түвшинд бэлтгэгдсэн манай профессор, багш нар судалгааны ажлын арвин туршлагатай.

“Байгалийн нөөц, технологи”-ийн шинжлэх ухааны магистрын хөтөлбөрт суралцсанаар тухайн оюутан инженерчлэл, байгалийн шинжлэх ухааны мэдлэгээ улам бүр хөгжүүлэхээс гадна тэднийг бие даасан, хэрэглээнд суурилсан судалгааны ажил хийх чадварыг сайжруулах зорилготой. Энэхүү Ахисан түвшний сургалтын хөтөлбөрийг МГТИС-ийн Герман улс дахь түнш их сургуулиудын хамтын ажиллагааны үр дүнд, Монгол Улсын аж үйлдвэрлэлийн салбарын онцлог хэрэгцээнд нийцүүлэн боловсруулсан болно.

МГТИС нь үүсэн байгуулагдсан цагаасаа дадлагад суурилсан сургалт, ажлын байрны бодит туршлагыг оюутнуудад олгох чиглэлээр олон улсын тэргүүлэх компаниудтай хамтран ажиллаж ирсэн. Иймээс Магистрын хөтөлбөрийн (M.Sc.) оюутнууд нь аж үйлдвэрийн хэрэгцээнд тулгуурласан “Ахисан түвшний судалгааны төсөл” дээр ажиллах замаар Магистрын дипломын ажлаа тухайн салбартайгаа нягт уялдаатай, ихэвчлэн ажил олгогчтойгоо хамтран хийх боломжтой.

“Байгалийн нөөц, технологи”-ийн шинжлэх ухааны магистрын хөтөлбөр нь онолын үндэслэл, бодит судалгааг хослуулах замаар ажил мэргэжлийг чухалчлан үйлдвэрлэлийн салбарын хэрэгцээ шаардлагыг шууд хангахад чиглэсэн. Тус хөтөлбөр нь заавал судлах хичээл (инженерийн судалгааны арга зүйг түлхүү анхаарсан), өргөн сонголттой сонгон суралцах хичээл (салбар хоорондын модулиудыг багтаасан), Ахисан шатны судалгааны төсөл болон Магистрын дипломын ажил зэргээс бүрдэнэ. Ингэснээр мэргэшлийн хувьд давуу сонголтуудыг бий болгож, оюутныг инженерийн болон байгалийн шинжлэх ухааны аль алианаар нь хөгжих боломжийг олгоно.

Бид танд юуг санал болгох вэ?

- Олон улсын түвшинд магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөртэй төрийн өмчит их сургуульд суралцан, судалгааны ажлын туршлага хуримтлуулах;
- Инженер болон байгалийн шинжлэх ухааны ирээдүйд эрэлттэй чиглэлүүдээр мэдлэг, ур чадварыг эзэмших;
- Олон улсын мэргэжилтнүүдээс онолын болон судалгааны заавар зөвлөгөө авах;
- Сургалтын орчныг дээд зэргээр бүрдүүлсэн орчин үеийн дэвшилтэт технологи бүхий лекцийн танхим, олон улсад эрэлттэй номын нөөц бүхий номын сан, Aspen Plus, MATLAB, LIMN The Flowsheet Processor, Maptek Vulcan 12 болон COMSOL Физик зэрэг дэлхийд тэргүүлэх мэргэжлийн програм хангамжтай компьютерийн лабораторид суралцах;
- Англи хэлний мэдлэгээ сайжруулахаас гадна техникийн англи хэлийг эзэмших;
- Тусгай техникийн мэдлэг, салбар хоорондын аргачлалыг бий болгодог инновацын модулиудтай танилцах;
- Судалгааны чиглэлээр өндөр мэргэшсэн шинжлэх ухааны магистрын (M.Sc.) зэрэг эзэмших;
- Мэргэжлийн цар хүрээгээ тэлэх, олон улсын болон Монгол улсын нэр хүнд бүхий компаниудад ажиллах боломж бүрдэх;
- Орлогын бодит өсөлт болон дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжил эзэмших;
- Цаашид докторын зэрэг хамгаалах зэргээр эрдэм шинжилгээний салбарт ажиллах ажил мэргэжлийн гарааны суурь болно.

Та яагаад МГТИС-ийн магистрын хөтөлбөрийг сонгох хэрэгтэй вэ?

Дахин давтагдашгүй: Монгол Улсын аж үйлдвэрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, салбар хооронд хөрвөх чадвартай, судалгааны чиглэлээр мэргэшсэн шинжлэх ухааны магистрын зэрэг

Нэр хүнд: Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн их сургуулиас эрэлттэй эрдмийн зэрэг хүртэх боломж;

Мэргэшсэн чиглэл: Олон салбарын өргөн цар хүрээ бүхий судалгааны арга зүйг эзэмших;

Хөрвөх чадвар: Судалгаа, инновацын чиглэлээр мэргэшин инженерийн болон байгалийн шинжлэх ухааны салбарт хөрвөж ажиллах;

Бизнес сэтгэлгээ: Инженерчлэлийн бодит асуудлыг шийдвэрлэх бүтээлч хандлага, шийдлийг олж нээх;

Ахисан түвшний судалгаа: Аж үйлдвэрлэлийн салбарт чиглэсэн Ахисан түвшний нарийвчилсан судалгааны төсөл болон судалгааны мэргэжлийн зөвлөхийн удирдлага дор ажиллах;

Гэрээсээ гадаадад суралцах: МГТИС-ийн болон хамтрагч их сургуулиудын санал болгосон хичээлийн хөтөлбөрөөр суралцах;

Ажил мэргэжлийн өргөн боломж: МГТИС-ийн инженерчлэл болон шинжлэх ухааны салбар дахь (уул уурхай, үйлдвэрлэл, боловсруулалт, байгаль орчин гэх мэт) харилцаагаар дамжуулан олон улсын компаниудад ажиллах;

Манлайлал: Монголын компаниудад удирдах албан тушаалд дэвшин ажиллах;

Ирээдүйд чиглэсэн: Аж үйлдвэрлэлийн салбарын шинэ чиг хандлагатай хөл нийлүүлэх;

Англи хэл: Инженерийн болон шинжлэх ухааны хэлээр өндөр түвшинд чөлөөтэй харилцах;

Амжилт: МГТИС-д Шинжлэх ухааны магистрын зэрэг эзэмших нь танд дараагийн амжилтуудын үндэс суурь нь болох нь эргэлзээгүй.

“Байгалийн нөөц, технологи”-ийн шинжлэх ухааны магистрын хөтөлбөр нь инженерийн болон хэрэглээний судалгааны чиглэлээр амжилттай ажиллахад таныг бэлтгэнэ. Та 21 дүгээр зууны инженерийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шинэ санаа, туршлагыг боловсруулж, нэгтгэх боломжтой болно.

Энэхүү сургалтын хөтөлбөр нь заавал судлах хичээлүүд, сонгон суралцах хичээл (олон төрлийн мэргэшил олгох боломжийг бүрдүүлэх), мөн практиктай холбогдсон судалгааны ажил гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэнэ. Сургалтын хөтөлбөрийг орчин үеийн хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй ажлын орчинд шаардлагатай хамгийн чухал агуулга, арга зүйг багтаах замаар боловсруулсан бөгөөд тогтмол сайжруулдаг. Ахисан түвшний судалгааны төслийн гол онцлог нь хувь хүний бие даасан байдал, хариуцлагыг өндөр түвшинд хөгжүүлж, онолын сургалтын үед эзэмшсэн мэдлэг, ур чадварыг батжуулдаг оршино. Ингэснээр тус хөтөлбөр нь таны Магистрын зэрэг (M.Sc.) горилох дипломын ажилд чухал бэлтгэл болно.

Энэхүү зэрэг олгох хөтөлбөрийн туршид та Монгол, Герман болон олон улсын профессоруудын лабораторийн ажил, бодит асуудал дээрх хэлэлцүүлэг, бие даасан төсөл, салбартаа тэргүүлэгч компаниудтай хамтран ажиллах зэрэг төрөл бүрийн сургалт судалгааны хөтөлбөрт хамрагдана. Нийтдээ Байгалийн нөөц, технологийн шинжлэх ухааны магистрын хөтөлбөр нь судалгаа, шүүмжлэлт дүгнэлт, мэдлэг чадварыг бүтээлч сэтгэлгээ, санаачилгатай байхыг хөгжүүлэхэд чиглэнэ.

Ажлын байр

Энэхүү ахисан түвшний хөтөлбөрт хамрагдсанаар судалгаа, боловсруулалтын салбарт инженер, эрдэм шинжилгээний чиглэлээр ажиллахад шаардагдах ур чадвар, мэдлэгийг бүрэн эзэмших болно. Уул уурхай, боловсруулалт, үйлдвэрлэл, механикийн системийн загварчлал боловсруулах, эрчим хүч цахилгаан үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүчний систем, хүрээлэн буй орчны инженерчлэл, төслийн менежмент, үйлдвэрлэлийн инженерчлэл гэх зэрэг бусад салбарт ажиллах боломжтой. Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас явуулсан судалгаагаар нийт төгсөгчдийн дөнгөж 33 хувь нь өөрсдийн төгссөн мэргэжлийнхээ чиглэлээр ажилладаг гэсэн дүн бий. “Байгалийн нөөц, технологи”-ийн шинжлэх ухааны магистрын хөтөлбөр (M.Sc.) нь бакалаврын зэрэгтэй хүмүүст мэргэжлээ дээшлүүлэх, ажил мэргэжлийн цар хүрээгээ өргөжүүлэх онцгой боломжийг олгож байна. Энэхүү хөтөлбөрийн төгсөгчид нь цаашид инженерчлэл, шинжлэх ухаан болон холбогдох бусад чиглэлээр докторын сургалтад хамрагдах боломжтой.

Сургалтын төлбөр

Олон улсын, тэргүүлэх зэрэглэлийн боловсрол эзэмшихэд өртөг өндөр хэдий ч МГТИС-ийн сургалтын төлбөр харьцангуй боломжийн байдаг. Нэг багц цаг (ECTS) нь 133,000 төгрөгийн төлбөртэй.

Тавигдах шаардлага

- Инженерийн болон байгалийн ухааны чиглэлээр бакалаврын зэрэгтэй, доод тал нь 180 багц цаг (ECTS-CP) буюу түүнтэй дүйцэхүйц багц цагийг судалсан байх;

Боломжит бакалаврын зэргээс дурдвал: Механик инженер, Мехатроник инженер, Барилгын инженер, Түүхий эд боловсруулалтын инженер, Боловсруулалтын инженер, Химийн инженер, Эрчим хүч, цахилгааны инженер, Хүрээлэн буй орчны инженер, Эдийн засагч инженер, Физик, Хими, Гео шинжлэх ухаан болон Мэдээллийн технологи гэх мэт.

- Англи хэлний түвшин: IELTS 6.0 эсвэл TOEFL 60-78 оноо, эсвэл МГТИС-ийн Англи хэлний түвшин тогтоох тест өгсөн байх шаардлагатай. Элсэгчид англи хэлний C1 буюу ахисан түвшин хангаагүй тохиолдолд эрчимжүүлсэн хэлний бэлтгэлд хамрагдана.

- Хэрэв та багц цагийн (ECTS-CP) шаардлагыг хангасан эсэхдээ эргэлзэж байвал МГТИС-ийн Элсэлтийн хороотой admission@gmit.edu.mn хаягаар холбогдон тодруулга авна уу.

Элсэлтийн бүртгэл

Элсэлтийн бүртгэл 12-р сарын 31-ний өдрийг хүртэл нээлттэй явагдаж, хаврын семестрийн хичээл 2-р сарын 1-нээс эхэлнэ. (эсвэл намрын семестрийн бүртгэл 7-р сарын 31-ний өдрийг хүртэл нээлттэй явагдаж хичээл нь 10-р сарын 1-ний өдрөөс эхэлнэ). Бүртгэл цахимаар явагдах бөгөөд дараах хаягаар <http://gmit.edu.mn/register> баримт бичгийг фэйлаар хавсарган илгээнэ үү. Үүнд:

- Бакалаврын зэргийн дипломын хуулбар;
 - Дипломын дүнгийн хуудас;
 - Англи хэлний түвшин тогтоох шалгалтын гэрчилгээ (байхгүй тохиолдолд МГТИС-ийн Англи хэлний түвшин тогтоох шалгалтыг өгөх боломжтой);
 - Суралцахыг хүссэн өргөдөл (англи хэлээр);
 - CV / товч намтар (англи хэлээр);
 - Иргэний үнэмлэхийн хуулбар.
- Бид таны хүсэлтийг хүлээн авахдаа таатай байх болно.

Сургалтын хөтөлбөрийн ерөнхий мэдээлэл

“Байгалийн нөөц, технологи”-ийн шинжлэх ухааны магистр нь 120 кредит цагтай (ECTS-CP), хоёр жилийн хугацаатай сургалтын хөтөлбөр юм. Магистрантурт элссэн оюутнууд дараах хичээлүүдийг амжилттай судлах ёстой.

Заавал судлах хичээл (шинжлэх ухааны ба инженерчлэлийн арга зүй)

Туршилтын загварчлал
Инженерийн статистик
Оптимизацийн аргууд
Инженерийн ёс зүй
Инновац ба энтрепренер

Сонгон судлах хичээлүүдийг судалгааны чиглэлтэй уялдуулан сонгох боломжтой

Аж үйлдвэрт зориулсан судалгаа, хөгжлийн арга зүй (R&D)
Уул уурхай, аж үйлдвэр дэх технологи
Инженерийн арга зүй (Механикийн, Боловсруулалтын, эсвэл Эрчим хүчний инженерийн)
Байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт
Инновац ба технологийн менежмент
Техникийн / инженерийн төслийн менежмент
Ахисан түвшний судалгааны төсөл
Магистрын дипломын ажил

Манай бүртгэлийн хуудсанд хандаж, өргөдөл гаргах заавартай танилцана уу.

<http://gmit.edu.mn/register>



Бүрэн тоноглогдсон лабораторид хийгдэх судалгааны ажил.